

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 06 дугаар
сарын 15-ны өдөр

Чойр хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /мянг. төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх түвшин	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал болоесруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал болоесруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1.1.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, дээд газраас ирүүлсэн холбогдох журам, заавар, дүрэм, зөвлөмжийн хэрэгжилтийг байгуулах.	Шаардлаагүй	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-ас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	2024 оны 01 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын багц хуулийг аймаг орон нутагт сурталчилан 228 ажил олгогч, 6200 даатгуулагчийг хамруулан багц хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шинэ хууль батлагдсантай холбогдуулан гарсан дүрэм, журам заавруудыг үйл ажиллагаандыаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, нийт ажил олгогч даатгуулагч, иргэдэд сурталчилан таниулах мэргэжил арга зүйгээр хангах ажлуудыг хийж ирсэн. Энэ оноос системийн хэмжээнд нэвтэрч байгаа Sicoc программ хангамжийг өдөр тутамын үйл ажиллагаанд нэвтрүүлэн дээд байгууллагаас ирүүлж буй шинэчлэл, өөрчлөлтийг тухай бүр хугацаанд нь гүйцэтгэж, үүрэг даалгаврыг биелүүлэн хэвийг ажиллах нөхцөл боломжийг аймгийн хэмжээнд бүрдүүлэн гарч буй хүндэрэл бэрхшээлийг тухай бүрэн шийдвэрлэн ажил олгогч, иргэд, даатгуулагчдад нөхцөл боломжийг ойлгуулан	100%

						нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, удирдлагаар ханган шийдвэрлэж ажиллаа.	
1.1.2.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх.	Шаар д-лагагүй	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо	2023 онд 143 хүнийг сайн дурын даатгалд шинээр, үүнээс 35 малчин шинээр хамруулав.	Сайн дурын даатгалд 2024 онд 166 даатгуулагч, үүнээс 52 малчин даатгуулагчийг шинээр хамруулж, хамралтын төлөвлөгөөг биелүүлсэн байна.	<p>Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын хөдөөгийн 4 багийн өдерлөгт оролцон 225 малчин иргэнд нийгмийн даатгалын ач холбогдол, хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй Шинэ хоршоо хөдөлгөөнөөр орон нутагт шинээр байгуулагдан үйл айл ажиллагаа эхлүүлсэн 25 хоршооны малчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж заавар журмыг таниулцуулан, нийгмийн даатгалд сайн дураар 31 малчинг хамрууллаа. Цаашид малчдын сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор ХХААГазар, ХХҮГ-ын малжуулах төслийнхөнтэй хамтран ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - 2024 оны эхний 6 сарын байдлаар 100 иргэнийг шинээр нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрууллаа. Дээрхи даатгуулагчдын ангилан харуулбал: -Малчин даатгуулагчийн тоо-45 -Энгийн СДД тоо -10 -0-3 настай эхчүүдийн тоо-30 -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эх-15 байна. 	100%
1.1.3.	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх.	Шаар д-лагагүй	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо	2023 онд 7 ажил олгогч, 23 хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав.	Ажил олгогчийн тоог 11, даатгуулагчийн тоог 55 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	<p>Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, даатгалд бүртгүүлээгүй аж ахуйн нэгжийг нийгмийн даатгалд хамруулах чиглэлээр газрын даргаар батлуулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээний шимтгэл төлөгч ажил олгогчийн судалгааг гаргаж, шинээр хамруулах боломжтой ажил олгогч 8 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж Нет капитал, Нинжбелгээ, Суутбуян зэрэг 6 ажил олгогчийг шинээр нийгмийн даатгалд хамрууллаа.</p> <p>-Ажил олгогчийн тоо-6 Даатгуулагчийн тоо-16</p>	100%

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг ургийг хэрэгжүүлэх зорилт						
"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:						
2.1.1.	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах..	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл	Нийгмийн даатгалын санд 2023 онд 17,656.2 төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 22,680.6 төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	Нийгмийн даатгалын 4 санд 2024 оны 5 сарын байдлаар 8 324 016,7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулахаас 9 518 732,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төвлөрүүлж төлөвлөгөө сан тус бүрээр 100,0-114,4 хувиар биелүүлж ажиллаа. <u>Сангудын орлогыг авч узвэл:</u> 1. Тэтгэврийн даатгалын санд 678160,7 мянган төгрөгийн шимтгэл оруулахаас 7710853,4 мянган 2. Тэтгэмжийн даатгалын санд 707558,2 мянган төгрөгийн шимтгэл оруулахаас 815508,9 мянган төгрөг, 3. ҮОМШӨ-нийдаатгалын санд 560864,6 мянган төгрөг оруулахаас 832267,6 мянган төгрөг 4. Ажилгүйдлийн даатгалын санд 273973,2 мянган төгрөгийн шимтгэл оруулахаас 160102,0 мянган төгрөг тус тус оруулсан байна. Нийгмийн даатгалын сангаас 2024 оны эхний 6 сарын байдлаар 12 173 689,3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгохоос 11 419 843,2 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр хугацаанд нь бүрэн олгосон байна. <u>Сангудын зарлагыг авч узвэл:</u> 1. Тэтгэврийн даатгалын сангаас 11 113 689,7 мянган төгрөгийн тэтгэвэр олгохоос 10 224 092,2 мянган төгрөг олгосон. 2. Тэтгэмжийн даатгалын сангаас 914 089,7 мянган төгрөгийн тэтгэмж олохоос 685 228,7 мянган төгрөг олгосон. 3. ҮОМШӨ-нийдаатгалын сангаас 244 093,0 мянган төгрөг олгохоос 179 281,5 мянган төгрөг олгосон. 4. Ажилгүйдлийн даатгалын сангаас 465 816,9 мянган төгрөгийн тэтгэмж олгохоос 331 240,8 мянган төгрөг тус тус олгосон байна.	100%

2.1.2.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөх ажиллах.		Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл	Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд ... сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөх ажилласан байна.	2024 оны эхний 5 сарын байгууллагын үйл ажиллагааны батлагдсан 274 259,1 мянган төгрөгийн зардлыг захиран зарцуулахаас 237 395,9 мянган төгрөгийн зардалыг зориулалтын дагуу зарцуулан ажиллаа. Ажилтнуудын цалин, нэмэгдэл, хөнгөлөлт, урамшуулалд 156 777,1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 18 289,6 мянган төгрөг, төрийн захирагааны албан хаагчийн хөдөө орон нутагт тогтвортой ажиллуулах тэтгэмжид 27 135,8 мянган төгрөг, ажилтнуудын нийгмийн баталгааны болон ахмад настнуудын буцалтгүй тусламжид 1936,0 мянган төгрөг, байгууллагын байр ашиглалтын зардалд 28 661,1 мянган төгрөг, Бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбооны зардалд 2 778,8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2 041,8 төгрөгийг тус тус батлагдсан зардал ангилаал, зориулалтын дагуу хэмнэлтийн хуулийн хүрээнд үнэн зөв хэмнэлттэй зарцуулан ажиллаа.	100%
2.1.3.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.		Батлагдсан 21 684 928.80 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана.	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 17 785 837.16 төгрөгөөр буюу 96.6 хувиар биелүүлсэн.	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 21 684 928.80 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.	2024 оны сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх ажлын хүрээнд газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 16-ны А/16 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй авлага барагдуулах ажлын хэсгийг томилон, төлөвлөгөө гарган 14 хоног тутам үр дүнг тооцон ажиллаж байна. Үүний үр дунд эхний 5 сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 8 324 016.7 мянган төгрөг байхаас 9 518 732,0 мянган төгрөг төвлөрүүлж, сар бүр шимтгэлийн орлогыг 100-114 хувиар биелүүлж ажиллаа.	100%
2.1.4.	ЭМДЕГ-аас эрүүл даатгалын ажил шимтгэлийн орлогын мэндийн сангийн олгогчийн орлогын		ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна.	ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 3 186 944.44 мян.төгрөг төвлөрсөн	ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна.	Эхний 5 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын санд 1 762 156,5 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 110 хувь биелүүлсэн.	100%

	төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.			байна.			
2.1.5.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг хүргүүлэх.	Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 26.32 хувиар өссөн байна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна.	2024 оны эхний үлдэгдэл авлагыг барагдуулах НДЕГ-ын даргын энэ оны А/64 дугаар тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 16-ны А/16 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй авлага барагдуулах ажлын хэсгийг томилон, баталсан төлөвлөгөөний дагуу өртэй ААНБайгууллагуудыг ажлын хэсгийн гишүүдэд хуваарилан хариуцуулж 14 хоног тутам үр дүнг тооцон ажилласнаар оны эхний 5 сарын нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар бүр биелүүлэн нийгмийн даатгалын санд 1 128 088,0 мянган төгрөгийг төвлөрүүлээд байна. 2023 онд үүссэн авлагын насхилтийг шинэчлэн гаргахад 120 хоногийн насхилттай 31 аж ахуй нэгжийн 4240121,5 мянган төгрөг, 120 хоногоос дээш насхилттай 42 аж ахуй нэгжийн 7760114,6 мянган төгрөгийн нийт 73 байгууллагын 8184236,2 мянган төгрөгийн хуримтлагдсан авлага байна. Авлага барагдуулах ажлын хүрээнд 58 аж ахуй нэгжийн байгууллагудын удирдлага, санхүүгийн албатай уулзалт зохион байгуулж 2 байгууллагатай гэрээ байгууллаа. Шивээ-Овоо ХК, Тэнүүн сондор мед ХХК төлөх өрийн хуваарийг батлан хэрэгжилтэнд хяналт тавин 7, 14 хоногоор үр дүнг тооцон ажиллаж байна/ Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 4 байгууллагын 208400,1 мянган төгрөгийн авлагыг Шүүхийн байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлж байна. /Чойрхайрхан-195,0, Арвижих-Оюу-8,0, Сүмбэр шүтээн-3,3, Түшигчойр констракшн-2,1/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад авлага барагдуулахаар 2 байгууллагын 139941,0 мянган /Чойрхайрхан-93,0 Говьгео-46,9/ төгрөгийн авлагыг барагдуулахаар хамтран ажиллаж байна. Өмнөх оны нийт авлагын 89%-ийг буюу 7300612,2 мянган төгрөгийг Шивээ-Овоо ХК дангаараа эзэлж байгаад дүгнэлт хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөвлөгөөт Хяналт шалгалтын ажлын ахлах	90%	

					<p>н.Наранцэцэгээр ахлуулсан шалгалтын ажлын бүрэлдэхүүнтэй компанийн удирдлагын уулзалт хийж өр төлөх хуваарьт өөрчлөлт оруулан газар дээр нь нэхцэл байдалтай танилцан өр үүссэн шалтгаан барагдуулах арга замын талаар тодорхой ойлолт, үр дүнд хүрч ажиллахаар боллоо.</p> <p>Авлага барагдуулах ажлын хүрээнд 2024 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар оны эхний авлагаас 37 байгууллагын 571420,8 мянган төгрөгийн ерийг барагдуулан ажиллаа. Хуримтлагдсан авлага 6,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна..</p>	
2.1.6.	Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгүй барагдуулах	Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгүй гарсан байна.	Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн.	Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөгүй байна.	2023 онд үүссэн сайн дурын даатгуулагчийн он дамнуулан шилжүүлсэн шимтгэлийн өглөг нь системийн хэмжээнд хийгдэж байгаа программ хангамжтай холбоотойгоор эхний хагас жилийн байдлаар тодорхой хувиар буураагүй байна. Тайлант оны жилийн эцсээр бүрэн барагдуулж ажиллана.	90%
2.1.7.	Бусад өглөг, авлагыг барагдуулах.	Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна.	Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна.	a) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах. б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах.	A) 2023 оны сангийн бусад авлага 19744,7 мянган төгрөг, өглөг 28784,9 мянган төгрөг байна. Дээрхи бусад өр авлагын үүссэн шалтгаан, насхилтын байдалд судалгаа хийж барагдуулах боломжийг судлан төлөвлөгөө гарган ажиллаж байна. Б) Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өр, авлага байхгүй байна.	80%
2.1.8.	НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.	НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.		НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.	2024 оны эхнээс 11280888,5 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, нийгмийн даатгалын төв санд өдөр бүрэн төвлөрүүлэн ажиллаа.	100%

2.1.9.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.	Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 31 278 632.30 төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	a) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 31 278 632.30 төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.	A). 2024 эхний 6 сарын байдлаар 2573 тэтгэвэр авагч иргэнд 10 224 092,2 мянган төгрөгийн тэтгэврийг сар бүрийн 1-ны өдөр бүрэн олгож ажиллаа. Б). Нийгмийн даатгалын сангаас 2024 оны эхний 6 сарын байдлаар 12 173 689,3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгохоос 11 419 843,2 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр хугацаанд нь бүрэн олгосон байна. Сангудын зарлагыг авч үзвэл: 1. Тэтгэврийн даатгалын сангаас 11 113 689,7 мянган төгрөгийн тэтгэвэр олгохоос 10 224 092,2 мянган төгрөг олгосон. 2. Тэтгэмжийн даатгалын сангаас 914 089,7 мянган төгрөгийн тэтгэмж олохоос 685 228,7 мянган төгрөг олгосон. 3. УОМШ-ний даатгалын сангаас 244 093,0 мянган төгрөг олгохоос 179 281,5 мянган төгрөг олгосон. 4. Ажилгүйдлийн даатгалын сангаас 465 816,9 мянган төгрөгийн тэтгэмж олгохоос 331 240,8 мянган төгрөг тус тус олгосон байна	100%
2.1.10.	Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах.	Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана.	Батлагдсан 616 491.00 төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 495 120.72 төгрөг зарцуулсан.	a) Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б) Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна.	A). 2024 оны эхний 5 сарын байгууллагын үйл ажиллагааны батлагдсан 274 259,1 мянган төгрөгийн зардлыг захиран зарцуулахаас 237 395,9 мянган төгрөгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулан ажиллаа. 36863,2 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Б) 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилсан эрхийн дагуу төсвийн хэтрүүлэлтгүйгээр хэмнэлттэй зарцуулж байна. Зардлын ангилал хооронд сольсон хэтрүүлэн зарцуулсан санхүүгийн зөрчил гаргаагүй болно. В). Ажиллагсад болон байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан өр авлага үүсээгүй болно.	100%
	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Санхүүгийн болон төсвийн	Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын сангийн	2024 оны эхнээс сар, улирлын санхүүгийн тайлан мэдээг хуульд заасан хугацаанд бүрэн хүргүүлж	

2.1.11.	тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах		гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн гаргаж, ирүүлсэн.	санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	ажилласан. Нийгмийн даатгалын сангийн мэдээ 6 удаа, Үйл ажиллагааны зардлын зарцуулалтын мэдээ-6 удаа 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг 3 дугаар сарын 15-ны дотор тус тус гаргаж хүргүүллээ.	100%
2.1.12.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.		Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	-Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бурд нь бүртгэлд тусгах;	Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/18 дугаартай тушаалаар байгууллагын Үндсэн хөрөнгө тооллого явуулах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон 6 дугаар сарын 12-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай тооллогын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	100%

					<p>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх; -Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх; -Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;</p>	
--	--	--	--	--	--	--

				-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах; -Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна.		
2.1.13.	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.	Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	a) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга,	a) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга,	A). 2023 оны жилийн эцсийн сангудын болон үйл ажиллагааны санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагаар шалгуулж, нийгмийн даатгалын сангийн тайландаа тусгагдаагүй авлага /7974,0 мянга/ барагдуулсан шалтгаанаар хязгаарлалтай дүгнэлт гарсан. Б). Аудитын байгууллагын хийсэн шалгалтаар өгөгдсөн залруулгыг шалгалтын явцад барагдуулан ажилласан. Акт, зөвлөмж, албан шаардлагыг хүлээн авч зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байгаа ба биелэлтийг хагас бүтэн жилээр аудитын байгууллагад хугацаанд нь хургуулэхээр ажиллаж	80%

			өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна.	байна.	
2.1.14.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг дүгнэх НДЕГ-т хүргүүлэх.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна.	Хаан банк, Төрийн банк байгуулсан гэрээний хэрэгжилтэд сар бүр хяналт тавьж хамтран ажиллаж байна. Гэрээг 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дүгнэн биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газарт хүргүүлнэ.	100%
2.1.15.	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх	Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаанд нь гарган хүргүүлж, нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазын жилийн үйлчилгээ хийлгэсэн. Энэ оноос хэрэгжих байгаа шинэ системд ажил олгогчийн үндсэн мэдээлэл, өглөг авлагын эхний үлдэгдэл, сайн дурсын даатгуулагчийн өглөг авлагын эхний үлдэгдэл, даатгуулагчийн мэдээллийг системд үнэн зөв бүртгэх ажлыг 1 дүгээр сард зохион байгуулан ажилласан. Ажил олгогч, даатгуулагчийн шилжүүлсэн орлогыг таниулах, бүртгэх ажлыг өдер бүр үнэн зөв мэдээллийн баазад оруулж байна. Мөн тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын анхан шатны баримтыг мэдээллийн баазад үнэн зөв бүрэн оруулах ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.	100%
2.1.16	Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн “Core” систем нэвтрүүлж байгаатай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газар, Ай Ти Зон ХХК-иас ирүүлж буй чиглэл, үүрэг даалгаврын дагуу газрын байцаагч, ажилтнуудыг	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн “Core” систем нэвтрүүлж байгаатай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газар, Ай Ти Зон ХХК-иас ирүүлж буй чиглэл, үүрэг даалгаврын дагуу газрын байцаагч, ажилтнуудыг	100%

	нягтлан бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой хэрэгжүүлэх.	бодох ажлыг	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.	байгуулсан ажлуудад оролцсон.	ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.	нэгдсэн удирдлагаар ханган тухай бүр хэрэгжилтийг гүйцэтгэн ажиллаж байна.	
2.1.17	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах		Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	a) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	A) Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тооцооны үлдэгдлийг тухай бүр холбогдох байгууллагаар баталгаажуулан ажиллаа. Б)Харилцагч байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, тэтгэвэр, тэтгэмж авагчийн тооцоог сар, улирал бүрээр бүрэн баталгаажуулан ажиллаж байна.	100%
2.1.18	ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх		Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.	Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.	a) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн	A). 2024 оны 1 дүгээр сард эрүүл мэндийн даатгалын 3 дансыг хааж, үлдэгдэл 2556,0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд төвлөрүүлсэн. Б). 3903 дансны үлдэгдлийг 2023 оны эцсийн байдаар даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т хүргүүлсэн. В). 3303 дансанд бүртгэлтэй байгаа ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалтаар НДЕГ-т хүргүүлсэн.	100%

			тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	ан.	тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна. в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулсан НДЕГ-т ирүүлнэ.	
--	--	--	---------------------------------------	-----	--	--

Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг уургийг хэрэгжүүлэх зорилт

Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслацаа үзүүлэх

3.1.1.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих;	Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан.	Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна.	Газрын даргын тушаалаар ил тод мэдээллийг хариуцсан ажилтанг томилон байгууллагын албан ёсны мэдээллийг "Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газар" цахим хуудсанд нийтлэн ажиллаж байна. Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг бүрэн байршуулсан. Засгийн газрын https://shilen.gov.mn сайтад мэдээллийг бүрэн бүртгэж, илгээх төлөвт шилжүүлсэн байна.	100%
--------	---	---	---	--	--	------

			Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна.		
3.1.2.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;					<p>Байгууллагын шилэн дансны мэдээлэлд хяналт тавин ажиллах ажилтнаар сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхцэцэгийг томилон ажиллуулж байна. Эхний 6 сарын байдлаар шилэн дансны мэдээлэл хоцорсон зөрчил илрээгүй.</p> <p>Шилэн дансанд нийт 171 мэдээллийг мэдээллэхээс хугацаандаа 76 мэдээллийг оруулсан.</p> <p>Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй.</p> <p>Цаашид мэдээллэх 95 мэдээлэлийг хугацаа болоогүй байна.</p> <p>Тайлант онд нөхөж байршуулсан мэдээлэл байхгүй болно.</p>	100%

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах

	Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана.	Илэрсэн төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан.	Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	2024 онд хяналт шалгалтын баталсан төлөвлөгөөний дагуу 15 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж 10 аж ахуй нэгжид улсын байцаагчийн 7161,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон бүрэн барагдуулсан байна.		100%
	Үйлдвэрлэлийн осол,	21 аймаг, 9		ҮОМШӨ-ний сангийн	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар		

3.2.3.	мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалахий	дүүргийн хэмжээнд ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад хяналт шалгалахийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дунд хяналт тавьж ажиллах,	-	<p>бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах</p> <p>тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө" -ний дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/08 дугаар "Үйлдвэрлэлийн осол, мэргэжилээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалахийх тухай" удирдамжийн дагуу Монгол улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хууль, "Нийгмийн даатгалын тухай" хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн үйл ажиллагаа, орлого бүрдүүлэлт, зарцуулалтын чанар, үр дунд үнэлгээ, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах зорилгоор Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын Үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны санхүүгийн баримтанд тулгуурлан хяналт шалгалахийсэн.</p> <p>Шалгалааар 2021-2023 онд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж бусдаар гүйцэтгүүлэхдээ зөвхөн 1 байгууллагыг 3 жил дараалан сонгож байгаа нь ашиг сонирхолын зөрчил үүсэхгүй гэх газаргүй учир цаашид сонголтыг өөрчилөх</p> <p>Шинээр хэрэгжих байгаа Нийгмийн даатгалын хууль холбогdon гарч байгаа журам, дүрмийг хэрэгжүүлэх, иргэд даатгуулагчад хүргэх, сурталчилах ажил хангалтгүй байгаад анхаарч ажил сайжруулах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.</p> <p>ҮОМШӨ-ий даатгалын сангаас Хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэврийг олон жил авч байгаа даатгуулагчид шинэ батлагдсан хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгоход тэтгэврийн хэмжээ буурахгүй болохыг ойлгуулсаны дагуу тэтгэврийн нөхцөлийг солих /шалгалтын явцад 3 даатгуулагчд хуулийг таниулж ХЧАТэтгэврийг зогсоон өндөр насны тэтгэврийг шинээр тогтоосон/</p> <p>ҮОМШӨ-ий даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийг 5 жилээр цалинг өөрчилөх өргөдлийг гаргуулан 2024-06-01-нээс 3 даатгуулагчид 500,0 мянган төгрөгийн тэтгэврийн зөрүүг олгосон.</p>	100%
3.2.4.	Нийгмийн хамгааллын хяналтын их, дунд үнэлгэдсэн эрдэлтэй	Хяналт шалгалахийсэн объектын тоогоор гүйцэтгэлийн	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг	<p>Нийгмийн хамгааллын салбарын хяналтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу тээврийн 2 байгууллагад хяналт шалгалах явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг 100 хувь барагдуулан ажилласан. Хяналт шалгалахийг төлөвлөгөөнд</p>	100%

	объектод төлөвлөгөөт шалгалт хийх	хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зэрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь		шалгаж, зөрчлийн доошгүй барагдуулах	ирэлсэн 70-аас хувийг	тусгагдсаны дагуу ирэх улиралд хийгдэнэ.	
3.2.5.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах,	Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб программаар” (http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ.	21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб программаар” (http://10.9.0.5/monitoring)-аас зориулж, илэрсэн зөрчлийн 80,0 тогтмолжуулж, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб программаар” (http://10.9.0.5/monitoring)-аас зориулж, илэрсэн зөрчлийн 80,0 тогтмолжуулж, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ.	Салбарын программ хангамжийн шинэчлэлтэй холбоотой цахим хяналтын вэб программ 2024 оны өгөгдлийг татаж хянах боломж бүрдээгүй байна.	100%
3.2.6	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зэв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тулган	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зэв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тулган	Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн	Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан	Дотоод хяналт шалгалтаар 2024 онд шинээр тогтоосон 72 тэтгэврийн, ХЧТА 354 тэтгэмжийн, ЖАН 127 даатгуулагчийн тэтгэмжийг, ажилгүйдлийн тэтгэмж авагч 260 даатгуулагчийн тогтоолт олголтонд дотоод хяналт шалгалтыг хийж, тэтгэвэр, тэтгэмжийг олгох ажлыг зохион байгуулан газрын даргад танилцуулан ажиллаа.		100%

	баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хургүүлэх,	даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хургүүлнэ.	актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.		
--	--	--	--	--	--

Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

4.1.1.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол	Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, аймгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүрт хугацаанд нь хургүүлж ажиллаж байна.	100%
--------	--	--	--	--	---	------

	өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.			шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэлгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна	хүргүүлнэ.	
4.1.5.	Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх	Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолто ор заагдсан чиг Үүргийг хэрэгжүүлсэн байна.		Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх.	Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Иргэд даатгуулагчид тав тухтай үйлчл боломжоор хангах үүднээс газрын үйлчилг заалны засварыг 2 дугаар сард өөрсдийн н боломжоор хийж гүйцэтгэлээ. Иргэд даатгуулагчдад үзүүлэх үйлчилгээг 1 шуурхай хүргэх зорилгоор телефон утасны "с ярих үйлчилгээ шинээр 4 дүгээр сараас хэрэгжүүлэн нэвтрүүллээ. Байгууллагын гадна өнгө үзэмжийг сайжруул барилгын гадна өнгийг сэргээж, хөг бэрхшээлтэй иргэдэд зориулсан ханын ба зориулалтын нойл, угаалтуурыг шинэчлэн ш хийж эхэлсэн.

4.1.6.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.	Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна.	Нийгмийн даатгалын байгууллагад тогтвортой суурьшилтай ажиллаж байгаа 4 албан хаагчдад Төрийн захираганы албан хаагчийн хөдөө орон нутагт тогтвортой ажилласаны урамшуулалт 27 135,8 мянган төгрөгийг олгосон. Газрын харьят өндөр настан, 12 ахмадуудад сар шинийн хүндэтгэл үзүүлэн 637,0 мянган төгрөг олгосон. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах ёдрийг тохиолдуулан нийт ажилтан, албан хаагчдын 32 хүүхэд, амьдралын боломж тааруу 1 өрхийн өрх толгойлсон авын 2 хүүхэд нийт 34 хүүхэд гарын бэлэг гардууллаа.	100%
Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах						
4.2.2.	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах;	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн удаагийн сургалтад иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр 4 дүгээр багийн өдөрлөг, хуулийн байгууллагуудын Про-Боно өдөрлөг, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын өдөрлөгүүдэд оролцож 350 иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэж ажилласан байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж 200 иргэн хамруулсан.	100%
4.2.3.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн суржээгээр өргөнөөр	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн тоо, мэдээллийн төрөл.....	Нийгмийн даатгалын хуулийн шинэчлэл, холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, ажиллагаа, цаг үеийн мэдээллийг	Орон нутгийн Говьсүмбэр телевизтэй хамтран газрын үйл ажиллагааны танилцуулга, 2 удаагийн нэвтрүүлгийг 4 удаагийн давтамжтайгаар цацаж ажилласан. Нийгмийн сүлжээгээр 17 төрлийн постор, мэдээ мэдээллийг оруулж 51 удаагийн давтамжтайгаар түгээж ажиллаа. Хандалтын тоо 1700 гаруй байна. Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулж байгаа шинэчилсэн хуулийн сурталчилгаа богино хэмжээний видео бичлэгийг Өмнөговь	100%

	сурталчлах;;	<p>мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбууک)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтолт бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгаан ы тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл</p>	<p>орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>аймгийн Нийгмийн даатгалын газартай хамтран цахим сүлжээнд түгээн ажилласан байна. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар богино хэмжээний 4 контент бэлтгэж аймгийн хууль зүйн хэлтсийн контент оролцлоо.</p>	
--	--------------	--	--	---	--

Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх

			Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна.	223 аж ахуй нэгж байгууллагын ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарын бүрэн бүрдүүлэн тайланг хүлээн авч байна.	100%
4.4.1	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх		Ажил олгогчийн НДШ-ийн тайландаа ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх		- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.	223 ажил олгогчийн давхардсан тоогоор 6800 даатгуулагчийн үндсэн мэдээллийг шалгаж, тайланг хүлээн авч ажиллаа. Даатгуулагчийн үндсэн мэдээлэл буруу орсон тохиолдол гаралаагүй байна. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ашиглагдаж байгаа нийгмийн даатгалын цахим системд буруу төрлеөр орсон даатгуулагчийн мэдээллийг ажил олгогчийн хүсэлтийн дагуу шийдвэрлэж ажиллаж байна. Програм хангамж хэвийн горимоор ажиллаж эхэлсэн тул цаашид дээрийн алдааг гаргахгүй ажиллах бүрэн боломжтой. Давхардсан тоогоор 6800 даатгуулагчийн улсын код, ажил мэргэжлийн ангиллыг үнэн зөв хүлээн авч ажиллаж байна.	
	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх		Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна..	Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна.	223 ажил олгогчийн тайланг сар бүр хүлээн авч баталгаажуулахдаа тушаалын бүртгэлийг шалгаж хүлээн авч байна.	
				Ажил олгогчийн	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тооцоог давхардуулан бүртгэх тохиодол дотоод хяналт шалгалтаар илрээгүй болно.		

4.4.2			дэвхардуулан бүртгэхгүй байх	үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан..			100%
			Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр дэвхардуулан бүртгэхгүй байх		Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр дэвхардуулан бүртгэхгүй байна. дээр нэг даатгуулагчийг нэгээс илүүгүйгээр тайлан <u>тусгуулсан</u> байна.	Дотоод хяналт шалгалтаар дээрхи алдаа гараагүй байна.	
			Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх		Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна.	Дотоод хяналт шалгалтаар дээрхи алдаа гараагүй байна. Цаашид хяналт шалгалтыг тогтмол хийнэ.	
	Дүн					35 арга хэмжээ 3440	98.2%

ГОВЬСУМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН САНХҮҮ БҮТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б. АЮУШЖАВ,